

Гурав дахь Мянган Институт

Сайнмэдээний Тэмдэг

Есүс дөхөж ирээд, тэдэнд "Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуул. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав."

Матай 28:18-20

Энэ бол Матайн Сайнмэдээнд буй Есүсийн тэнгэр өөд одохынхоо өмнө хэлсэн хамгийн сүүлчийн үгс билээ. Хэрэв танд хайртай дотнын хүмүүстээ эцсийн үгээ хэлэх боломж олдвол та юу гэх байснаа төсөөлөөд нэг үзээрэй. Таны хэлэх үгс юу байх бол? Ямартай ч цаг агаар, ажил төрөл, эсвэл дуртай багийн чинь сүүлийн онооны тухай байхгүй нь мэдээж. Харин та зүрх сэтгэлийнхээ үгийг хэлэхийг хүсэх нь лавтай. Есүс ч бас энд зүрх сэтгэлийнхээ үгийг л хэлсэн юм. Тэрээр дагалдагч нарынхаа сонсох ёстой хамгийн чухал зүйлийг хуваалцсан. Дагалдагч болгож бэлтгэх нь Түүний зүрх сэтгэлийн хүсэл мөн. Есүсийн эрхэм зорилго ба чин сэтгэлийн хүсэл бол Хаанчлалын Сайнмэдээг түгээж, дагалдагч бэлтгэх явдал билээ. Дагалдагч бэлтгэх эхний алхам бол мэдээж Сайнмэдээг тунхаглах нь юм. Тэгэхээр энэхүү Сайнмэдээний тэмдэг гэсэн хэсэгт та өөрийн амьдарч буй нөхцөлд Сайнмэдээг тунхаглана гэдэг нь юу болох, мөн хэрхэн ийнхүү тунхаглах талаар ярилцана. Түүнээс гадна Их Эзэнийг хараахан мэдээгүй байгаа хүмүүст өөрийн гэрчлэлээ хуваалцах боломж ч гарах болно.

Тэмдгийн бүрэлдэхүүн хэсгүүд:

Сайнмэдээний танилцуулга - Сайнмэдээг танилцуулахдаа ямар зүйлсийг багтаах ёстой тухай сурна.

Хувийн гэрчлэл - Сайнмэдээг хуваалцахдаа өөрийн гэрчлэлийг хэрхэн ашиглах тухай ярилцана.

Сайнмэдээний туршлага - Сайнмэдээг хэн нэгэнтэй хуваалцахдаа сурсан мэдсэн зүйлсээ ашиглана.

Хэлэлүүлгийн Сэдвүүд:

1. Дараах асуултанд өөрийн үгээр хариулна уу: Сайн мэдээ гэж юу вэ? хариултаа бүлгээрээ хэлэлцээрэй.
2. Танай улсад сайнмэдээ тараах үйл явц хэрхэн явагддаг вэ? Хүмүүс үүнд хэрхэн ханддаг вэ? Танай улсад сайнмэдээ тараах хамгийн түгээмэл арга юу вэ?
3. Сайн мэдээг танилцуулахад заавал оруулах ёстой хамгийн чухал хэсгүүд юу вэ? Жагсааж бичнэ үү? Бичсэн жагсаалтаа 6 болон түүнээс цөөн үндсэн зүйлд багтааж цомхгтоорой.

4. Танай улсад сайнмэдээ тараах хамгийн үр дүнтэй арга юу вэ? Танихгүй хүмүүст сайнмэдээ тараах илүү үр дүнтэй юу эсвэл таньж мэддэг хүндээ сайнмэдээ тараах нь илүү үр дүнтэй юу?
5. Та танидаг болон таньдгүй хүндээ сайн мэдээ тараахдаа хэрхэн ялгаатай арга барил хэрэглэдэг вэ?
6. Танай улсад сайнмэдээ тараах хэр аюултай вэ? Бусдад сайнмэдээ тараахад тань энэ нөхцөл байдал хэрхэн нөлөөлдөг вэ?

Хувийн гэрчлэл:

Хүнд бүр анх Есүс Христэд итгэж Түүнийг хэрхэн өөрийн Аврагч Эзэн болгосон тухай түүх, хувийн гэрчлэлтэй байдаг. Таны гэрчлэл бол бусдын амьдралыг өөрчлөх хүчтэй чухал түүх бөгөөд та үүнийг хэзээ ч ашиглаж болдог. Та анх хэрхэн Есүсийг өөрийнхөө Аврагч гэдгийг ойлгож мэдсэн тухайгаа бод. Тэгээд бусдад 3 минутад багтан ярьж болох гэрчлэлээ бэлдээрэй. Ингэж бэлтгэхэд тань доорх гурван алхам тус болно.

1 алхам: Таныг Есүсийн тухай сонсохоос өмнө таны амьдрал ямар байсан бэ? Тэр үеийн нөхцөл байдал тань таны гэрчлэлийг сонсох хүнд хэрхэн холбогдох вэ?

2 алхам: Есүсийн тухай сонсож түүнд итгэхэд тань ямар нөхцөл байдал нөлөөлсөн бэ? Сайнмэдээ бол үнэн гэж ойлгоход тань юу нөлөөлсөн бэ?

3 алхам: Есүс Христэд итгэлээ өгснөөс хойш таны амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ? тэр өөрчлөлт таны гэрчлэлийг сонсох хүнд ямар холбоотой вэ?

Хийх зүйлс:

1. Гэрчлэлээ бичээд цээжил. Тэгээд бүлгийн бусад гишүүддээ болон бүлгийн сургагчдаа ярьж өг.
2. Есүст итгэдэггүй хүнд ярьж үз.
3. Бусдад хэрхэн хуваалцсан тухайгаа бүлгийн гишүүд болон сургагчидтайгаа ярилц. Сайн зүйлс юу байв. Мөн сайжруулах зүйлс юу байв.

Тэмдэг шаардлага:

Энэ тэмдэгтийг Суурь Мэдлэгийн Сертификатын бүрэлдэхүүн болгож Гурав Дах Мянган Институтээс өгдөг бөгөөд үүнийг авахын тулд суралцагч **Хийх Зүйлсийн** даалгаврыг **Тэмдэгтийн Бүрэлдэхүүн хэсгүүдийн** дагуу курсын явцын турш **Хэлэлцүүлгийн Сэдвүүдийн** хүрээнд чамбай гүйцэтгэсэн байх шаардлагатай.